



Asia South Pacific Association
for Basic and Adult Education
Learning Beyond Boundaries

ҮЙЛ АЖИЛЛАГААНД СУУРИЛСАН
ЗАЛУУСЫН СУДАЛГАА

“

КОВИД – 19 ЦАР ТАХАЛ
ТОДОРХОЙ БҮЛГИЙН
ЗАЛУУСТ ХЭРХЭН
НӨЛӨӨЛСӨН БЭ?

”

УИХ МН
СУДАЛГААНЫ САН





Asia South Pacific Association
for Basic and Adult Education
Learning Beyond Boundaries

ҮЙЛ АЖИЛЛАГААНД СУУРИЛСАН
ЗАЛУУСЫН СУДАЛГАА

“ КОВИД – 19 ЦАР
ТАХАЛ ТОДОРХОЙ
БҮЛГИЙН
ЗАЛУУСТ ХЭРХЭН
НӨЛӨӨЛСӨН БЭ? ”

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот
2020 он

Төслийн нэр: Үйл ажиллагаанд суурилсан залуусын судалгаа II

Тайлангийн агуулга: Ковид 19-ын нөхцөл байдалд залуусын боловсрол, амьдралын хэв маяг, сэтгэлзүйд гарсан өөрчлөлтийг аман түүхийн аргаар өгүүлсэн.

Судлаачид: Д.Ангарагсүрэн, Б.Батчимэг, Д.Бат-эрдэнэ, Ц.Галбадрах, Ц.Оюунчимэг, Г.Халиунаа, О.Үүрийнцолмон, Э.Энхмаа

Эмхэтгэсэн: Я.Мөнхчимэг

Хянасан: Д.Тунгалаг

Зураг Д.Давааням

ASPBAE - Суурь болон насанд хүрэгсдийн боловсролын төлөө Ази, Өмнөд Номхон далайн нийгэмлэгийн санхүүжилтээр хэвлэв.

БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ! ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ НЬ

(Боловсрол эвсэл) боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 30 гаруй иргэний нийгмийн байгууллагуудыг эгнээндээ нэгтгэсэн боловсролын бодлогын судалгаа, шинжилгээний ажил хийх, сургалт зохион байгуулах, бодлого боловсруулахад оролцох зэрэг чиглэлээр бодлогын болон олон нийтийн нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг үндэсний хэмжээний төрийн бус байгууллага юм. Боловсрол эвсэл нь ASPBAE (Суурь болон насанд хүрэгсдийн боловсролын төлөө Ази, Өмнөд Номхон далайн нийгэмлэг)- гийн гишүүн байгууллага бөгөөд хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, тэтгэлэг өгөх, бүсийн түвшинд насанд хүрэгчдийн болон суурь боловсролын асуудлаар бодлогын нөлөөлөл хийх зэргээр хамтран ажилладаг билээ.

БОДЛОГОД ЗАЛУУСЫН ХЯНАЛТ ТББ нь хүний эрх, ардчиллын үнэт зүйлийн талаарх мэдлэг ойлголтыг түгээх замаар залуу хүн бүрийг бие даасан, идэвх, хариуцлагатай иргэн болгон төлөвшихөд нь дэмжлэг үзүүлж, нийгмийн бүхий л түвшинд залуусын оролцоог хангасан тогтвортой хөгжил бүхий хүмүүнлэг нийгмийг цогцлуулан хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилготой, бодлого боловсруулах үйл явцад оролцох залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах зорилгоор 2014 оноос эхлэн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй залуучуудын байгууллага юм.

Уг байгууллагын ажлын алба, удирдах зөвлөлд нь залуучууд ажилладаг гэдгээрээ онцлогтой бөгөөд “Засаглалд залуу сэтгүүлчдийн оролцоо”, “Улс төр ба мөнгө” хөтөлбөрүүд, “Эрх тэгш нийгмийн хүүхэд залууст” төслийн хүрээнд “Улаанбаатар хотын гэр хорооллын хүүхэд, залуусын хөгжих эрх ба төрийн үйлчилгээний хүртээмж” нөхцөл байдлыг тодруулах чанарын суурь судалгаа хийж олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

ТАЛАРХАЛ

Ковид–19 цар тахлын үеийн залуусын амьдралын нөхцөл байдлын талаарх “Үйл ажиллагаанд суурилсан залуусын судалгаа”-г хийж гүйцэтгэсэн Бүх нийт боловсролын төлөө! Иргэний нийгмийн үндэсний эвсэл болон Бодлогод залуусын хяналт ТББ-ын дэргэдэх “Залуусын давлагаа”, “Залуу ээжүүд”-ийн клубын залуу судлаачдадаа талархал илэрхийлье. Тэд судалгаанд оролцох залуучуудыг хайж олох, ярилцлага хийж байсан туршлага дутах, таньж мэдэхгүй гудамж, орчинд орж ажиллах, согтуу хүмүүс, гудамжны ноходод хөөгдөх гэх мэт асуудал, хүндрэл бэрхшээлтэй нүүр тулсан ч уйгагүй хичээл зүтгэл, тууштай чанарынхаа ачаар судалгаагаа амжилттай хийж гүйцэтгэсэн билээ.

Бодит, үнэн уран бүтээлүүдээрээ судалгааг маань амь оруулсан баримтат гэрэл зурагчин Дэлгэржаргалын Даваанямд баярлалаа.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ӨМНӨХ ҮГ

Дэлхий даяар Ковид - 19 цар тахлын тархалтыг зогсоох зорилгоор нийтийн эрүүл мэндийн төлөө авч хэрэгжүүлж буй арга хэмжээний нэг болох сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосноос үүдэн дэлхий даяар боловсролын тогтолцоонд урьд өмнө байгаагүй их сорилт бэрхшээл тулгарсан билээ. Ази, Номхон далайн бүсийн хэмжээнд боловсролоос завсардах эрсдэл бүхий бүлгийн залуус цар тахлын үед эмзэг нөхцөлд байхаас гадна хүнд сорилттой тулгарч байна хэмээн үзэж, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, Бодлогод залуусын Хяналт ТББ-тай хамтран ASPBAE (Суурь болон насанд хүрэгсдийн боловсролын төлөө Ази, Өмнөд Номхон далайн нийгэмлэг) – аас гаргасан арга зүй, зөвлөмжийн дагуу “Үйл ажиллагаанд суурилсан залуусын судалгаа”-г хийж гүйцэтгэлээ.

БНХАУ-ын Ухань хот Ковид-19 цар тахлын голомт болсноор иргэдийн эрүүл мэнд, нийтийн сайн сайхныг хамгаалах зорилгоор 1 сарын 24-ны өдрийн Улсын Онцгой Комиссын хурлын 1 дүгээр тогтоолоор 2020 оны 1-р сарын 27-ны өдрөөс сургууль, цэцэрлэгийг түр хугацаагаар хааснаас эхлэн коронавирусын нөхцөл байдалтай холбоотой албан ёсны шийдвэр, төрийн бодлого хэрэгжиж эхэлсэн билээ. Сургууль цэцэрлэгийг түр хааснаас үүдэн технологид холбогдоогүй алслагдсан газар амьдарч байгаа, эмзэг байдалд орсон, нийгэм эдийн засгийн статус доогуур өрхөд амьдарч буй сурагчид зайны сургалтад шилжсэнтэй холбогдуулан боловсролын үйлчилгээнээс гадуур үлдэх эхлэл болсон юм. Мөн урт хугацаагаар хилийн хориг тавих, орон нутгийн хөдөлгөөнийг хязгаарлах, зарим үйлчилгээний газруудыг хаах зэрэг арга хэмжээ авснаас үүдэн иргэдийн орлого буурах, сэтгэл зүйн хямралд өртөх, гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэх, архидан согтуурах явдал нэмэгдэх зэрэг сөрөг үр дагаврууд гарсан. Тиймээс цар тахлын энэ үед залуусын дуу хоолой, түүхүүд маш чухал мэдээлэл, эх сурвалж болно хэмээн үйл ажиллагаанд суурилсан залуусын судалгааг хийснээ та бүхэнд танилцуулж байна.

Залуу судлаачид тодорхой бүлгийн залуусын амьдралын хэв маяг, нийгэм сэтгэлзүй, эдийн засаг, боловсрол зэрэгт цар тахлын үеийн нөхцөл байдал

хэрхэн нөлөөлсөн талаар урьдчилан бэлтгэсэн асуултуудын хүрээнд ярилцаж, энэ нөхцөл байдлыг хэрхэн даван туулах, боловсролын талаар ямар хариу арга хэмжээ авч болох талаар ярилцаа. Уг судалгаанд хөдөө орон нутаг, гэр хороолол, асрамжийн газарт амьдардаг залуучууд, сонсголын болон харааны бэрхшээлтэй, тархины саажилттай залуус, өрх толгойлсон эхчүүд, бэлгийн цөөнх, үндэсний цөөнхийн төлөөлөл оролцсон юм. Залуу судлаачид уг судалгааг 2020 оны 5-6 сарын хооронд хийж, тайланг нэгтгэн боловсруулаад 8 сарын 21-нд Ази- Номхон далайн бүсийн залуусын чуулганд танилцуулсан болно.

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн

Ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



УЛС ОРНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд зааснаар 15-34 насны иргэнийг залуу гэж үзэхээр тогтсон. 2019 оны байдлаар нийт хүн ам 3,296,866 байгаагаас 15-35 насны 1,044,802 залуучууд байгаа ба Монголын нийт хүн амын 31,7 хувийг эзэлж байна¹.

Хүн амын 98,3 хувь нь бичиг үсэгт тайлагдсан буюу бичиг үсэг тайлагдалт манай орны нийт хүн амын дунд өндөр. Эдийн засгийн идэвхтэй залуучуудын бараг 11% нь ажилгүй. Ажил хөдөлмөр идэвхтэй эрэлхийлэхгүй байгаа залуучуудын тоог нэмбэл энэ хувь өсч, 16% хувьд хүрнэ. Монгол улсын нийт хүн амын 28,4 хувь нь ядууралд, 14,9 хувь нь ядууралд өртөх эрсдэлтэй гэсэн 2018 оны ядуурлын түвшний судалгаа² гарсан байдаг. Гэхдээ харьцангуй залуу хүн амын бүтэцтэй улс боловч залуусын ядуурал, эмзэг байдлын талаар тодорхой тоо мэдээ одоогоор танилцуулагдаагүй байна.

Техник, мэргэжлийн боловсролын сургалт (ТМБС) нь мэргэжлийн боловсролын сургалт, техникийн боловсролын сургалт, мэргэжлийн сургалт гэсэн хэв шинжтэй. ТМБС-ын нийт суралцагчийн 77% нь мэргэжлийн боловсролын хөтөлбөрт, 18% нь техникийн боловсролд, 5% нь мэргэжлийн ур чадварын гэрчилгээ авахаар сурч байна. 2018 оны байдлаар төрийн өмчит болон төрийн бус өмчийн 86 мэргэжил сургалт үйлдвэрийн төв (МСҮТ) үйл ажиллагаа явуулж байна. 2018-2019 оны хичээлийн жилд 37,039 суралцагч ТМБС-д хамрагдаж

1 Үндэсний Статистикийн Хорооны 2019 оны тайлангаас

2 ҮСХ "Ядуурлын дүр төрх" судалгаа, 2018 он

байгаагийн 26,445 нь төрийн өмчийн сургуульд хамрагдаж байна. Албан ёсны боловсролоос гадна мэдлэг, чадварыг албан бус богино хугацааны сургалтаар дамжуулан өгч, иргэдэд насан туршдаа суралцах боломж олгодог. Одоогоор 560 байгууллага богино хугацааны сургалт зохион байгуулдаг бөгөөд эдгээр нь магадлан итгэмжлэгдээгүй боловч албан бус боловсролоор чадамжийн сургалт зохион байгуулж байна.

2018 онд төрийн өмчийн 18 дээд боловсролын сургалтын байгууллага (ДБСБ) үйл ажиллагаагаа явуулснаас 14 нь их сургууль, дөрөв нь дээд сургууль байна. Нийтдээ төрийн бус өмчийн 73 их, дээд сургууль байдаг бөгөөд 21 нь их сургууль, 45 нь дээд сургууль, 7 нь коллеж (3 технологийн) үйл ажиллагаагаа явуулж байна. ДБСБ-ын 19% нь төрийн өмчийнх, нийт суралцагчдын 56% төрийн өмчийн ДБСБ-д суралцаж байна.

Залуучуудын 36% нь хөдөө орон нутагт амьдардаг, доогуур түвшний боловсролтой, албан бус салбарт ур чадвар шаардахгүй бага цалин хөлстэй, эрсдэл өндөртэй ажил хөдөлмөр эрхэлдэг ба нийгмийн хамгааллын гадуур байдаг.

Монголын хүн амын дунд сүүлийн жилүүдэд гарсан хамгийн том өөрчлөлт бол хөдөөнөөс хот руу болон гадаад руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн юм. Ялангуяа залуучууд амьдралын илүү сайн нөхцөл, боломж эрэлхийлэн шилжин суурьших магадлал ихтэй. Тухайлбал, 2000-2010 онд нийслэл Улаанбаатарт шилжин ирэгсдийн 60 орчим хувь нь 15-34 насныхан байснаас 15-24 насны залуучууд хамгийн өндөр хувьтай байв. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр 107 мянга гаруй монгол иргэд гадаад орнуудад зургаагаас дээш сараар оршин сууж байсан бөгөөд тэдний 63.0 хувь нь 15-34 насны залуучууд байв. Эдүгээ залуучуудын 72 хувь нь хотод амьдарч байгаа бөгөөд хотын таван оршин суугч тутмын хоёр нь 15-34 насны бүлэгт хамаарч байна. Шилжин суурьшсан залуучууд хэдийгээр эцэг, эх, уламжлалт дэмжлэгээс хөндийрч байгаа боловч өөр өөр давхаргын хүмүүстэй нүүр учирч харилцаагаа өргөжүүлэх, аж амьдралын шинэ соргог, олон төрлийн санаа, арга хэлбэрийг таниж мэдэх, илүү бие даах хандлагатай болдог. Нөгөө талаар тэд олон сорилттой тулгардаг.

2020 оны эхний 5 сард гадаад худалдааны нийт бараа эргэлт 3998.7 тэрбум долларт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 28.3 хувиар буюу 1579.7 сая доллараар буурчээ³. 2020 онд Анхан шатны шүүхэд гарсан гэр бүлийн хүчирхийллийн хэрэг 2019 оны 1-р улиралтай харьцуулахад 42 хэргээр буюу 87.5% -иар өссөн⁴

3 <https://www.customs.gov.mn/statistics/>, Гаалийн Ерөнхий газар

4 <https://ikon.mn/n/1uzv>, 2020 оны 4 сарын 22-ны мэдэгдэл, Шүүхийн Ерөнхий Зөвлөл

байна . Мөн 2020 оны 3 сарын 20-ны байдлаар 6000 орчим ажлын байрны тоо буурсан⁵ бөгөөд 4-р сард “Ажилгүйдлийн даатгалын сан”-гаас 7.5 мянган хүний ажилгүйдлийн даатгалын тэтгэмжид 17.0 тэрбум төгрөг зарцуулсан⁶ байна. Албан бус салбарт ажиллагсадын ихэнх нь хөл хорионы улмаас орлогогүй болж, сургууль хаагдсаны улмаас дижитал технологид холбогдоогүй алслагдмал нутагт амьдарч буй залуус, хүүхдүүд боловсролын системийн цахим болон теле хичээлээс хоцорлоо. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд маш бага төсөвтэйн дээр үйл ажиллагаа нь хаагдсан, теле хичээл явагдаагүй, цахимаар боловсрол олгосон ч нэмэлт дата худалдан авах шаардлагатай учир тэнд суралцдаг тодорхой бүлгийн залуус үргэлжлүүлэн суралцах боломжгүй болж боловсролоос хоцорсон. Мөн гадагшаа гарах хөдөлгөөнийг хязгаарласны улмаас зай талбай багатай гэртээ бүгэж, нийгэмших, үе тэнгийхэнтэйгээ харилцаж чадахгүй болсноор сэтгэл зүйн дарамт, айдас мэдэрч, тэдний нийгэм сэтгэл зүйн хувьд анхаарах шаардлагатай нөхцөл байдал үүссэн.

СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ

Боловсролын асуудлаарх Үйл ажиллагаанд чиглэсэн залуусын судалгаа (YAR) төсөл нь маргинал⁷ бүлгийн залуучууд Боловсролын асуудлаар судалгаа хийж, нөлөөллийн ажил хийх чадвартайг батлан харуулсан. Мөн охид, залуу эмэгтэйчүүд, залуу эрчүүд хэрхэн өөртөө итгэх итгэлийг олж авч манлайлагчид болж төлөвшин, ядуурал болон боловсрол эзэмшиж мөрөөдлөө биелүүлэх үйл явцад өөрсдөд нь саад болж буй соёлын хэм хэмжээг өөрчлөх, гарц шийдлийг эрэлхийлж чадахыг таниулсан.

Энэ удаагийн судалгааны зорилго нь Ковид–19 цар тахлын нөлөөг залуус өөрсдөө тодорхойлж, хувийн туршлага, түүхээ хуваалцах, түүнийг нь баримтжуулах байлаа. Мөн маргинал бүлгийн залууст чиглэсэн боловсролын хариу арга хэмжээг энэ судалгаагаар тодорхойлох оролдлого болж, тэдгээр залуусын дуу хоолойг олон нийт, шийдвэр гаргагчдад хүргэх эхний алхам болно хэмээн найдаж байна.

Энэхүү судалгааны асуулга, арга зүйг боловсруулах, тайлан болон зөвлөмжийг боловсруулах, төр болон бусад оролцогч талуудад судалгаанаас цугларсан мэдээллийг хүргэх үйл ажиллагааг залуучууд гардаж гүйцэтгэсэн бөгөөд

5 Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим, “Ковид 19: Бизнес дэх нөлөөллийн судалгаануудын нэгдсэн тайлан”, 2020 он

6 <http://www.ndaatgal.mn/v1/view/1412>, Нийгмийн Даатгалын Ерөнхий газар

7 Нийгмийн тэгш бус байдлаас үүдэлтэйгээр урт хугацаанд нийгэм эдийн засгийн статусын хувьд гадуурхагдаж, боловсролын бодлого төлөвлөлтийн хийдлийн улмаас сурч боловсрох эрх нь зөрчигдсөн, зөрчигдэх эрсдэлтэй бүлэг.

манлайлан оролцсон. Бас нэгэн чухал асуудал бол дээр дурдсанчлан үйл ажиллагаанд чиглэсэн судалгаа нь нийгмийг өөрчлөгч залуу манлайлагч, залуучуудын чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн.

Боловсрол эвсэл болон Бодлогод залуусын хяналт ТББ нь өөрийн байгууллагын зарчим, үнэт зүйл үйл ажиллагаанд суурилж оролцогчдын судалгааны арга зүй, нөлөөллийн болон манлайллын, стратегитайгаар, хүчтэйгээр залуучуудын дуу хоолойг олон нийтэд хүргэхэд хамтарч ажиллалаа.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

- Залуу судлаачидад чиглэл өгөх уулзалт (5-р сарын 2-7)
- 20 аман түүх цуглуулах (5-р сарын 7-30)
- Судалгааны тайлан (6-р сарын 20)
- Судалгааны тухай богино видео (6-р сарын 25)

Судалгааны хүрээ – 6 дүүрэг – Чингэлтэй, Сүхбаатар, Налайх, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан - 2 аймаг – Сүхбаатар, Ховд

СУДАЛГААНЫ ХҮРЭЭНД:

1. Ковид 19 цар тахлын үед амьдралд нь өөрчлөлт гарсан 20 залуугийн түүхийг цуглуулах
2. Эдгээр түүхүүдийг нэгтгэн дүн шинжилгээ хийх
3. Судалгааны ярилцлага хийж байгаа үйл явцаа фото эссе, аудио бичлэг, богино видео бичлэг зэрэг хэлбэрээр өөрийн гар утсыг ашиглан баримтжуулалт хийх
4. Ковид 19 цар тахлын болон гамшгийн үед нөхцөл байдалд авч хэрэгжүүлэх бодлогын болон бусад санал зөвлөмжийг боловсруулах
5. Өөрийн орон нутагт хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааг санаачлан гүйцэтгэх
6. Орон нутгийн засаг захиргаа болон төв засгийн газарт нөлөөлөх зорилгоор идэвхтэй хамтран ажиллах юм.

АМЬДРАЛЫН АМАН ТҮҮХҮҮД



ТҮҮХ: №1

Би 4 дүгээр сард ямаагаа самнаад онлайн хичээлдээ оролцож огт чадаагүй.

—19 настай, эмэгтэй, Сүхбаатар аймаг

Сургууль хааснаас хойш буюу 2 дугаар сарын 20-ноос цахимаар хичээлд суугаад семинарт оролцож, лекц сонсох нь миний хувьд маш хэцүү байгаа. Манай гэр сумын төвөөсөө ойрхон 6-7 км учир 20 минут унадаг дугуйгаар яваад хүрчихдэг. Тэнд ах эгч хоёр байдаг болохоор 2,3 хоногийн зайтай очоод интернет орж хичээлээ хийдэг. 25000 төгрөгөөр сарын хугацаанд хэрэглэх дата худалдаж аваад хичээлээ хангалттай үзэж татаж авч чаддаг. Манай хичээл ихэнх нь нээлттэй ч зарим нь тухайн цагтаа ороод л дахин давтаж үзэх боломжгүй байгаа учир тэр хичээлүүдийг бол тэгээд л орхисон. Болдог бол хичээлээ дараа жил нөхөж үзмээр байгаа. Манай сургууль цахим ном оруулсан байдаг ч мэдээлэл хангалттай олдохгүй байгаа. Тийм болохоор бие даалт гэх мэтээ огт хийж чадахгүй байна.

Мал төллөх үеэр (2-4 дүгээр сар) надад маш хэцүү байсан. Шалгалт, хөдөө гэрийн ажил давхцаад сумын төв рүү орж чадахгүй байсан. Хажуугаар нь манайх 100 гаруй ямаа самнадаг учир би 4 сард онлайн хичээлдээ оролцож чадаагүй. Би хотод сургуулийнхаа дотуур байранд амьдардаг байсан учир хагас жилийн амралтаараа хөдөө гэртээ ирээд тэр чигтээ хөл хорионд орсон. Дотуур байрнаасаа хувцсаа авч чадаагүй, одоог хүртэл өвлийн хувцастайгаа л байна.

Манай гэр бүл өдөр бүрийн 11 цагийн Эрүүл мэндийн яамны мэдээллийг үздэг. Сошиал медиагаар мэдээлэл огт авдаггүй.

Миний санааг зовоож байгаа ганц асуудал нь ноолуур зарагдахгүй байгаа нь манай санхүүгийн байдалд хүнд тусч байна. Ноолуур зарагдахгүй болохоор манайх гурил будаагаа ч худалдан авч чадахгүй байна. Ноолуур бол манай гэрийн амьжиргаагаа залгуулдаг гол зүйл. Төрөөс хүсэх зүйл бол ноолуураа л хурдан зармаар байна. Манайх жилийн турш зөвхөн ноолуур зарсан мөнгөөрөө л амьжиргаагаа залгуулдаг, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээс шууд хараат байдаг. Би олон дүүтэй, бүгдийнх нь хичээл номыг хийлгэхийн хажуугаар хониндоо явна, гэрийн ажил хийнэ, хичээлдээ анхаарна гээд өдөр маш завгүй өнгөрч байгаа.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ТҮҮХ: №2

Малчид бид ургах нарнаас эхлээд үдшийн бүрий хүртэл ажилладаг.

— 19 настай, эрэгтэй, Ховд аймаг

Коронавирусын улмаас хөл хорио тогтож хотруу хичээлдээ яваагүй, манай сургууль онлайнар хичээлээ зохион байгуулж эхэлсэн. Манай гэр сумаасаа 60 км зайтай байдаг тул утасны сүлжээ байхгүй. Би долоо хоногийн нэг өдөр сумын төв орж интернетээр хичээлээ хийж явуулдаг. Интернет маш удаан, надад компьютер байхгүй болохоор гар утсаараа хичээлээ үзэж, даалгавраа хийж явуулж байгаа. Надад хичээлд хэрэглэгдэх ном байхгүй, эндээс олдохгүй учир багшийнхаа оруулсан слайдаас харж хичээлээ хийж байна. Байнга утас ширтэж хичээлээ хийж байгаа учир миний нүд өвдөж, нулимс гоожиж, заримдаа улаан нүдтэй болчихдог болсон. Коронавирусын талаарх мэдээллийг өдөр бүрийн 11.00 цагийн ЭМЯ-ны мэдээнээс болон гар утсанд ирж буй мессежнээс авдаг тул хангалттай мэдээлэл авч байгаа гэж боддог.

Дунд сургуулийн телевизийн хичээлийн хувьд хөдөөний хүүхдүүд буюу манай дүү нар хичээл хийх ямар ч боломжгүй. Байнга хонь, малаа хариулаад аав ээждээ тусалдаг. Малчид бид ургах нарнаас эхлээд үдшийн бүрий хүртэл ажилладаг. Ковид 19-ын энэ үед гэр бүлийхэнтэйгээ бүгд хамтдаа байж, малаа маллаад, ажлаа хувааж хийгээд нэг бодлын гоё байгаа. Гэхдээ гэр бүлийн орлого буураад хүнсээ нөөцөлж чадахгүй хэцүү байна. Уг нь хавар ноолуураа зараад тухайн жилийнхээ өрхийн хэрэгцээний мөнгийг олдог байсан бол одоо худалдан авагч байхгүй шахуу тул орлогогүй байна.

Шийдвэр гаргах эрх мэдэлтэй байгууллагууд хөдөө орон нутагт интернетийн сүлжээтэй болговол малчин залуус малаа хариулж байхдаа хичээлээ хийх, өөр олон зүйлс суралцах боломжтой болно гэж боддог.

Өсвөр үеийхний бэлгийн боловсролын асуудлыг цар тахлын үед хэн ч ярихгүй, анхаарахгүй байна.

— *16 настай, эмэгтэй, Баянзурх дүүрэг*

Би төрөлхийн тархины саажилттай. Аав ээжтэйгээ хотын гэр хороололд амьдардаг, ерөнхий боловсролын дунд сургуульд суралцдаг. Хэдийгээр би тархины саажилттай ч өөрийгөө бусдад бүрэн ойлгуулж чаддаг. Коронавирус гарснаас хойш нийгмээс тусгаарлагдаж найз нөхөдтэйгээ уулзах минь багасаж, үүнээс болж сэтгэл санаа маань тогтворгүй болж, ганцаарддаг болсон. Бас ихэнх цагаа интернетэд, телевиз үзэж өнгөрөөх болсноор өдөр шөнийн нойр солигдож амьдралын минь хэв маяг өөрчлөгдсөн. Мөн аав ээжийн маань орлого багассан учир хоол хүнсээ бага багаар цуглуулдаг болсон нь хэцүү санагдаж байгаа.

Би тархины саажилтаасаа болж давхар харааны бэрхшээлтэй учир танхимд сууж хичээл үзсэнээс илүү дэлгэцээр хичээлээ судлах нь сонирхолтой, ойлгомжтой байгаа. Хоцорсон хичээлээ ангийнхаа фэйсбүүк группээс нөхөж үздэг.

Миний бодлоор цар тахлын үед хэн ч ярихгүй, анхаарахгүй байгаа сэдэв бол бидний үеийхний “бэлгийн боловсролын асуудал” юм. Ялангуяа, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд энэ талын мэдээлэл авч чадахгүй байгаа. Мөн хөл хорионд байгаа хүмүүст ганцаардлаа даван туулах, сэтгэлзүйн мэдлэг мэдээллийг түгээх хэрэгтэй байна. Цар тахлын үед ч, дараа нь ч төр засаг, залуучуудын байгууллага бидэн шиг нийгэмтэй харилцах харилцаа нь хязгаарлагдмал байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хооронд нь уулзуулах, сурч боловсрох ээлтэй, таатай орчин, компьютер гэх мэт хэрэгслүүдийг бүрдүүлэхэд анхаараасай гэж хүсч байна.

ТҮҮХ: №4

Теле хичээл үзэхээр заримдаа ойлгохгүй, тээнэгэлзэх асуудал гарч ирдэг.

— 15 настай, эмэгтэй, Баянзүрх дүүрэг

Манайх гэр хороололд амьдардаг, сургууль маань хотын төвөөс 20 орчим километрын зайтай учир би өдөр бүр сургууль руугаа явахдаа автобусанд ойролцоор 1 цаг орчим зарцуулдаг байсан.

Коронавирус гарахаас өмнө аав, ээж хоёр маань хоёулаа ажилтай байсан ч тахлаас болж ээж минь цомхотголд орж ажлаасаа халагдсан. Хааяа худалдааны төвүүдээр орохоор хүнсний бараа бүтээгдэхүүн хомс болсон нь ажиглагдаж байгаа.

Теле хичээл үзэхээр заримдаа ойлгохгүй, тээнэгэлзэх асуудал гарч ирдэг. Теле хичээлийн хугацаа дэндүү богино учраас бичиж тэмдэглэж амжихгүй байх тохиолдол гардаг. Ихэнх цагаа зурагт үзэж, интернетэд зарцуулж өнгөрөөж байгаа учир хөдөлгөөний хомсдолд орж жин нэмж байгаадаа санаа зовж байна.

Цар тахлын үед найз нөхөд, хамаатан садантайгаа уулзах маань багассан ч өөрөө өөртэйгээ ярилцах цаг зав ихтэй болсон. Хэдийгээр цаг үе хэцүү байгаа ч гэр бүлийхэнтэйгээ ойлголцож, бие биенийгээ хүндлэх болсон нь надад сайхан байгаа. Мөн төгөлдөр хуур тоглох цаг зав ихтэй болсон нь сайхан санагдаж байна. Миний хувьд бол төр засаг болоод залуусын байгууллагууд энэ цаг үед ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа хүмүүст эдийн засгийн тусламж үзүүлээсэй, хөл хорио зогссоны дараа сургуулиудад дугуйлан ажиллуулаасай гэж бодож байна.





ТҮҮХ: №5

Хөл хорио тогтоосноос хойш миний амьдралд гарсан хамгийн том өөрчлөлт бол дүү нартайгаа маш ойр дотно болсон явдал.

— 18 настай, эрэгтэй, Баянгол дүүрэг

Би өвлийн амралтаас хойш буюу 12 дугаар сарын дундаас хойш ганцхан удаа л гэрээсээ гарсан. Манай сургууль цахим сургалтын нэгдсэн системтэй хэдий ч багш нарын зарим нь фэйсбүүк, зүүм зэрэг аппликейшн ашиглан хичээлээ зааж байгаа. Боловсролын чанарын хувьд цахим сургалт нь танхимын сургалтаас үр дүн муутай байна. Амьд харилцаанд орж чадахгүй, зөвхөн тайлбартай, тайлбаргүй слайд хараад л хичээл хийж байгаа нь надад хангалтгүй санагдаж байгаа.

Манай гэр сургуулиас нилээн зайтай учир сургуульдаа явахгүй байгаа нь цаг их хэмнэж байна. Би чөлөөт цагаараа герман хэл үзэж байна, бас гэрээ үргэлж цэвэрлэдэг болсон. Мөн 2, 6 дугаар ангийн хоёр дүүтэй учир тэднийгээ өдөржингөө асарч, теле хичээлийг нь хийлгэхэд цаг их зарцуулж байна.

Ээж маань барилгын материал зарж амьжиргаагаа залгуулдаг учир цар тахлын үеэр барилгын компаниуд ажлаа зогсоосон нь эрэлт багассан байдалтай байна. Тиймээс манай гэр бүлийн эдийн засгийн хувьд бага зэрэг хямралтай байгаа. Энэ байдлаа даван туулахын тулд бид өдөрт 3 хоол идэхээ больж, талх масло авч өглөө, өдөр нь идээд, оройдоо ганц удаа хоол хийж идэж байгаа.

Би ахлах ангид байхаасаа л байнга гадуур ажилтай, хичээлтэй байдаг байсан учир бага дүү маань намайг бараг танихгүй шахам өссөн. Харин коронавирусын дэгдэлтээс болж хөл хорио тогтоосноос хойш миний амьдралд гарсан хамгийн том өөрчлөлт бол дүү нартайгаа маш ойр дотно болсон. Би Ковид-19 –ын талаарх мэдээллийг www.ikon.mn болон www.worldometr.com сайтаас авч байгаа. Цар тахлын нөлөөгөөр сэтгэл зүй маш хүнд байдалтай, бие махбодийн хувьд маш хөшингө болж байна. Манай гэр бүл гомофоби¹ биш, би гэр бүлийхэндээ өөрийгөө илэрхийлсэн. Гэхдээ гомофоби гэр бүлд байгаа ЛГБТ² хүмүүсийн хувьд гэр бүлтэйгээ их цаг өнгөрөөх шаардлагатай болж байгаа энэ үед гэр бүл нь дарамттай санагдаж, сэтгэл санаа нь хүнд байгаа байх гэж бодож байна.

Манай ээж “ганц бие ээж” учир Засгийн Газраас Ковидтой холбоотой гаргасан “18 хүртэлх насны хүүхдэд 100 мянган төгрөг өгөхөөр” болсон нь, мөн сар бүр 32 мянган төгрөгийн хүнсний талон өгдөг нь манай гэр бүлийн эдийн засагт нэмэр болж байна.

1 Лесбиян, гей хүмүүсээс айх айдас. ЛГБТ хүмүүсийг үзэн ядах, үл ойлгох байдлыг ялгаварлан гадуурхалт хэмээн бас тодорхойлдог.

2 Лесбиян, гей, бисексуал, трансжэндэр гэсэн үгсийн товчлол. ЛГБТ хэмээх үг нь бэлгийн цөөнхийг бүрэн төлөөлөх утгаараа зөв хэрэглээ болдог. ЛГБТ хэмээх товчлолыг хэрэглэхдээ хүмүүсийг төөрөлдүүлэхгүйн тулд заавал бүрэлдэхүүн үгсийг тайлбарлах нь зүйтэй.



ТҮҮХ: №6

Би маскаа өөрөө оёж хэрэглэж сурсан.

— 17 настай, эмэгтэй, Налайх дүүрэг

Хөл хорио тогтоод хичээлд явахгүй байх нь миний хувьд маш том өөрчлөлт байсан. Өдрийн турш гэртээ байж, гэрээ цэвэрлэнэ, дүүгийнхээ хичээлийг хийлгэнэ, хоолоо хийнэ гээд их ажилтай байдаг ч миний хувьд хичээлээ хийж амжиж байгаа.

Теле хичээл богино хугацаанд гарч байгаа учир тухайн хичээлийнхээ багш нараас нэмэлтээр даалгавар авч хийдэг. Гэр хорооллын нөхцөлд гараа байнга угаагаад байх боломж байдаггүй болохоор манай гэрийнхэн гар ариутгагчаар гараа байнга ариутгадаг. Нэг удаагийн маск маш үнэтэй, нэг ширхэг нь 1000 төгрөг байдаг бөгөөд “2 цаг тутам солих хэрэгтэй” гэхээр бидэнд тийм боломж байдаггүй. Иймд маскаа өөрөө оёж сурсан. Налайх дотроо өөрийнхөө оёсон маскыг зүүж, хот орох болохоороо л нэг удаагийн маск худалдаж авч байна.

Хөл хорионы эхэн үед вирус тархах вий гэсэн айдастай байсан ч одоо бараг дасаж байх шиг байна. Өдөр бүр ЭМЯ-ны 11.00 цагийн мэдээг үзэж коронавирусын талаарх мэдээллийг авдаг. Манай улсад вирусын халдвар байхгүй ч өөрийгөө хамгаалах зорилгоор маскаа зүүж, гараа байнга ариутгаж урьдчилан сэргийлэх арга хэмжээгээ үргэлжлүүлээд аваад явна гэж бодож байгаа.

ТҮҮХ: №7

**Цахим хичээл орж байгаа багшаасаа шалтгаалаад
өөр өөр платформ ашиглаж байна.**

—20 настай, эрэгтэй, Налайх дүүрэг

Дэлхий даяар коронавирус хурдацтай тархаж, манай улсад хөл хорио тогтоосноос хойш миний амьдралд зөндөө юм өөрчлөгдсөн. Амьдралын хэв маягт орсон хамгийн том өөрчлөлт гэвэл ихэнх цагаа гэртээ өнгөрүүлж байна. Өмнө нь би өглөө 5:30 цагт босоод 6:40-д эхний автобусанд сууж хотруу явдаг ч хичээлээсээ байнга хоцордог байсан. Харин хөл хорио тогтоосноос хойш гэрээсээ гарахгүй байгаа учир өглөө бүр үхэрнүүддээ өвс тэжээлийг өгөх, ус авч, түлээ бэлдэх гэх мэтийн гэрийн ажилдаа цаг зарцуулаад хичээлээ хийж амжихгүй тохиолдол ч гарч байна.

Би оюутан учир цагийн ажил хийж хэрэглээнийхээ мөнгийг олдог байсан. Одоо ажил хийж чадахгүй байгаа. Манай сургуулийн хичээл цахимаар орж байгаа боловч оюутан бүрт харилцан адилгүй хүртээмжтэй байгаа. Суурин байгаа хүүхдүүд бол хийж байгаа байх, харин хөдөө орон нутагт байгаа ангийнхан маань мал төллөөд их завгүй байгаа гэсэн. Хичээл орж байгаа багшаасаа шалтгаалаад бид өөр өөр цахим платформ ашигладаг. Номын сан ажиллахгүй, цахимаар номын хүртээмж муу учир мэдээллийн эх сурвалжаа интернетээс хайж олж авч байна.

Ковид-19 цар тахлын талаарх мэдээллийг өдөр бүрийн ЭМЯ-ны 11.00 цагийн хэвлэлийн бага хурлын мэдээгээр болон Worldometr, ikon.mn сайтаас авдаг. Аав маань холын тээврийн жолоочийн ажил хийдэг байсан ч Ковид 19-ээс болоод ажилгүй болсон нь санхүүгийн хувьд маш том дарамт болж байна. Амны хаалт маш үнэтэй, хуучин 3 ширхэгийг авдаг үнээр одоо 1 ширхэг амны хаалт авч байгаа учир ээж гэртээ амны хаалт оёж өгдөг болсон.

ОИГ.МН
СУДАЛГААНЫ САН

**Биднийг дохионы хэлээр яриад зогсож байхад
бусад хүмүүс “маскаа зүү” гэж загнаад байдаг
болохоор хоорондоо ч харилцахад бэрх байна.**

— 20 настай, эрэгтэй, Сүхбаатар дүүрэг

Цар тахлын энэ үед миний амьдралд их өөрчлөлт гарсан. Надад мөнгө маш их хэрэгтэй ч коронавирус гараад гэрээсээ гарч чадахгүй байгаа учир их хэцүү байгаа. Гадуур гарахдаа байнга маск зүүж байгаа тул бусадтай харилцаж чадахгүй байгаа. Биднийг дохионы хэлээр яриад зогсож байхад бусад хүмүүс “маскаа зүү” гэж загнаад байдаг болохоор хоорондоо ч харилцахад бэрх байна.

Нэг амны хаалтыг 1000 төгрөгөөр авч зүүж байгаа тул мөнгөгүй болж байна. Юмны үнэ нэмэгдээд байгаа юм шиг мэдрэгдэж, хоол хүнсний хүртээмж багасч байна. Коронавирус гарахаас өмнө цалин багатай ч ажил хийж байсан бол одоо ажил олдохгүй байгаа. Гэхдээ миний бодлоор сонсголтой хүмүүсийн цалин өндөр, сонсголгүй хүнийх бага байдаг юм шиг санагддаг. Өмнө нь ажил хийж байхад хар бор, бохир ажлыг би хийдэг мөртлөө надаас хөнгөн ажил хийдэг сонсголтой залуусын цалин минийхээс өндөр байдаг байсан.

Коронавирусын хөл хориотой энэ үед надтай адилхан хүмүүс найзуудтайгаа уулзаж чадахгүй, сэтгэл санаагаар өөдрөг байж чадахгүй байгаа байх. Энэ үеийг хэрхэн даван туулахаа ойлгож хүлээж авч чадахгүй байгаа. Би өдөр бүр дохионы хэлээр гарч байгаа 11.00 цагийн мэдээ үзэж байгаа нь их тус болж байгаа. Гэхдээ телевизийн бусад мэдээний дохионы хэлмэрч маш жижиг хэмжээтэй байдаг тул би харж чаддаггүй. Тиймээс фэйсбүүкээр л дохионы орчуулгатай мэдээ үзэж байгаа. Манай ээж аав хөдөө байдаг учир коронагаас болоод хотод ирж чадахгүй байна.

Би сурдаггүй болохоор боловсролын хувьд өөрчлөлт гараагүй ч дүү маань сургуульдаа явахгүй өдөржин тоглож, унтаж, идэхээс өөр зүйл хийхгүй байгааг нь харахад их эвгүй байна. Бид одоо хөгжлийн бэрхшээлтэй хүний тэтгэмж болох 182 мянган төгрөгөөр амьжиргаагаа залгуулж байна. Гэхдээ өмнө нь ийм хэмжээтэй байгаагүй. Саяхан л энэ мөнгө ийм хэмжээнд хүрсэн.

Би коронавирус байхгүй болохоор ажилд орж цалин орлогоо нэмэгдүүлье гэж бодож байгаа ч яг одоо, энэ цаг мөчид юу ч төлөвлөж чадахгүй байна. Надад ирээдүйн талаарх ойлголт, бодол гэх зүйл огт алга. Коронавирусын хөл хорио, айдас бий болохоос өмнө миний амьдрал хэцүү байсан ч одоо бол бүр ч

хэцүү болж, яг яах ёстойгоо үнэхээр мэдэхгүй байна. Боловсролын хувьд дохионы хэлээр бидэнд боловсрол олгоосой, амьдралын тухай, ирээдүйгээ яаж төлөвлөх талаар ч юмуу, яаж зөв амьдрах талаар ч юмуу зааж өгөөсэй гэж хүсэж байна.

ТҮҮХ: №9

Анх удаа цахим хуралд сууж үзлээ, цахимаар сургалт явуулж үзлээ, бүгд шинэ сорилт болж байна.

— *25 настай, эмэгтэй, Налайх дүүрэг*

Коронавирусын цар тахлын хөл хорио тогтоосноос хойш миний амьдралд нэг их өөрчлөлт ороогүй. Би төрийн байгууллагад ажилладаг, ганц бие учир эдийн засгийн хувьд хүнд байдалд хараахан ороогүй гэж бодож байна. Надад хадгаламж байхгүй, өөртөө болон ээж аавдаа зарцуулаад дуусдаг.

Сургалт, уулзалтууд хийдэг ажилтай учир эхний үед цахим сургалтын хувьд маш хүндрэлтэй байсан, сургалтын чанарын талаар асуудалтай байна. Царай царайгаа хараад хичээл заадаг байсан бол одоо ганцаараа л цахимаар хичээл зааж, асар их хүчин чармайлт гаргаж байгаа. Цахимаар сургалт хийж байхыг захирал үзээд би алдчихсан байх вий дээ гэсэн айдас бий болж байна. Анх удаа цахим хуралд сууж үзлээ, цахимаар сургалт явуулж үзлээ, бүгд шинэ сорилт болж байна. Интернетийн хурдны хувьд ажил дээр гайгүй ч, гэртээ интернэт хэрэглэх боломжгүй байдаг. Дата худалдан авч фэйсбүүкээс мэдээллээ авч байгаа ч асар их мэдээллийн дундаас бодит, баримттай мэдээллийг авч чаддаггүй.

Засгийн Газраас залуучууд руугаа чиглэсэн бодлого гаргаасай гэж бодож байгаа. Жишээ нь: коронавирусын хөл хорионы үеэр зээлийг царцаах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн ажил хиймээр байгаа. Би залуучуудтай ажилладаг учир ажлын цагаар гадуур явж байгаа залууст төвийнхөө үйл ажиллагаа боломжийн талаар өөрсдөө явж танилцуулдаг. Мөн сошиал сүлжээгээр дамжуулан залуучуудтай шууд лайваар холбогдохоос гадна групп үүсгэж, мессэнжэрээр мөн санаа оноог нь авч ажилдаа тусгадаг.

ТҮҮХ №10

Стрессээ уурлаж л бууруулахаас өөр ямар нэг арга хэмжээ авч чадахгүй байгаадаа санаа зовж байна.

— 17 настай, эмэгтэй, Сүхбаатар дүүрэг

Өвлийн амралтын үеэр ээж маань хөлөө гэмтээгээд босож чадахгүй болсон учир би 2 дүүгээ харах шаардлагатай болсон, бас цагийн ажил хийж халаасны мөнгөө олдог тул өөрийн хичээлээ огт үзэж чадаагүй. 5 сараас эхлээд хичээлүүдээ нөхөж үзэж байгаа ч маш хурдан гараад өнгөрдөг, бас утсаараа хичээл үздэг тул нүд их өвддөг.

Би гэр хороололд амьдардаг учир гэрийн ажил дуусна гэж байхгүй, харин ч өмнөхөөсөө ихэссэн. Худгаас ус авах, түлээ бэлдэх гэх мэт гэрийн ажилтай. Дүү нар маань сургууль, цэцэрлэггүй, гэрээсээ гарахгүй байгаа учир манай хоол унд, ахуйн хэрэглээний зардал өссөн. Би хичээлээ байнга нөхөж үздэг болохоор утасны төлбөр өндөр гарч миний санхүүгийн байдалд нөлөөлж байна. Цагийн ажлын байр маш хомс, дээр нь сурагч болохоор ажил олдохгүй байгаа нь хэцүү байгаа. Би цагийн ажил хийж хувийнхаа санхүүгийн хэрэгцээг гэр бүлээсээ хараат бусаар хангадаг. Тиймээс Засгийн Газрын зүгээс залуусыг ажлын байртай болоход дэмжээсэй гэж хүсэж байна.

Сэтгэл зүйн хувьд нилээн өөрчлөлт орж ааштай болсон байх гэж бодож байна. Стрессээ уурлаж бууруулахаас өөр арга хэмжээ авч чадахгүй байгаадаа маш их санаа зовж байгаа. Би өөрөө күйр хүмүүсийн төлөөлөл, бэлгийн чиг баримжааныхаа талаар эцэг эхдээ мэдэгдэх цаг болоогүй байгаа тул гэрээс гарахгүй байгаа энэ үед тэдэнд баригдах вий гэсэн айдастай байна. Мөн миний үеийнхэн сошиалаар элдэв янзын группт элсээд, тэндээсээ цахим халдлагад өртөж байгаа явдал түгээмэл болж буй учир аав, ээж миний хувийн орон зай руу халдах сэдэл болж байгаа. Би үүнээс болоод маш их айдаг болсон.



ТҮҮХ: №11

Манай дүүрэгт хүүхэд залууст зориулсан спорт зал, кофе шоп бараг байдаггүй учир бид ямар ч зорилгогүй гудамжинд уулзаж, алхдаг.

— 18 настай, эрэгтэй, Налайх дүүрэг

Хөл хорио тогтоосноос хойш коронавирусын талаарх мэдээллийг өглөө бүрийн 11.00 цагийн мэдээ болон www.ikon.mn сайтаас авдаг. Эхний үед энэ өвчин нийтээрээ тарчихвал яанаа гэж айж байсан ч одоо бол дор бүртээ хичээгээд, өөрөө өөртөө анхаарал тавих юм бол хамгаалж чадах юм байна гэдэгт итгээд, сэтгэл зүйн хувьд арай гайгүй болсон.

Анх телевиз болон онлайн хичээл зааж эхлэхэд тоогоогүй. Гэтэл багш теле хичээл хийхгүй бол дүн гаргахгүй гэснээс хойш хийж эхэлсэн. Теле хичээл 12 минут л үргэлжилж, дэндүү хурдан заагаад өнгөрдөг учраас хичээлээ хийхдээ байнга утсаар багштайгаа холбогдоод асууж байгаа. Теле хичээлийн хувьд монгол хэл, бичиг, уран зохиол ойлгомжтой байгаа ч хими, математик зэрэг хичээлүүд ойлгомжгүй байгаа.

Манай аав Таван толгойн уурхайгаас Хятад руу нүүрс зөөдөг байсан боловч ажилгүй болоод гэртээ байгаа учир гэр бүлийн санхүүд маш ихээр нөлөөлж байгаа. Харин ээж төрийн албанд ажилладаг учир цалинд нь өөрчлөлт ороогүй. Гэхдээ аав гэр бүлийнхээ санхүүгийн хэрэгцээг хангадаг байсан учир ахуйн хэрэглээ, хүнсээ танаж байгаа.

Мөн энэ үед гарсан эерэг зүйл нь аавтайгаа хамт цагийг өнгөрөөж байгаа нь сайхан байгаа, учир нь аав маань гэртээ байдаггүй, ярилцах боломж огт олддоггүй байсан юм. Харин одоо бид дотны найзууд болсон. Манай энд хүүхэд залуус чөлөөт цагаа өнгөрөөх спорт зал, кофе шоп бараг байдаггүй учир бид ямарч зорилгогүй гудамжинд уулзаж, алхдаг. Сургуулийн спорт залыг сурагчид үнэгүй хэрэглэдэг болмоор байгаа. “Хүүхэд залуучуудын хөгжлийн төв” гэж байгууллага байдаг ч хүүхдүүдийг оруулдаггүй, энд ямар үйл ажиллагаа болдгийг бид мэддэггүй.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ТҮҮХ: №12

Коронавирусын энэ үед дохионы хэлээр төрийн мэдээллээс эхлээд өөр гоё мэдээллүүд авч байгаа ч энэ нөхцөл байдал өнгөрөөд энэ бүхэн байхгүй болчих вий дээ гэж санаа зовж байна.

— 31 настай, эмэгтэй, Чингэлтэй дүүрэг

Ковид-19 цар тахлаас өмнө ажлын байр тогтвортой байсан бол одоо ажил тогтворгүй болсон. Би гэрээсээ ажиллаад, ажил дээрээ хаяа очиж байгаа учир цалингийнхаа 60%-г авч байгаа. Гэрээсээ ажиллаж байгаа учир ээж, дүү хоёртоо цаг зарцуулаад, тэдэндээ их анхаардаг болж “гэр бүл чухал шүү” гэж ойлгож эхэлж байна. Гадуур явах газар байхгүй, ихэнхи нь хаалттай байгаа учир найзуудтайгаа уулзаж мөнгө үрэхгүй давуу талтай ч амьдрал их уйтгартай байна. Би өмнө нь эрүүл мэндээ огт тоодоггүй байсан бол одоо анхаардаг болсон. Коронавирусын эхэн үед буюу 2-р сард амны хаалт гадуур олдохгүй, олдсон нь үнэтэй байсан бол одоо харьцангуй гайгүй болж байна. Манай ажлаас 7 хоногт 15 ширхэг амны хаалт өгдөг.

Энэ үеэр төрийн үйлчилгээнд өөрчлөлт ороогүй хэдий ч хэвлэл мэдээллийн хувьд маш их өөрчлөлт орсон. Дохионы хэлээр мэдээллүүдээ хүргэж байгаа нь их дэвшилттэй. Би саяхан шинэ ажилд орсон юм. Энд ихэнх нь сонсголтой хүмүүс учир тэдэнд зориулж сургалт хийж чадахгүй байгаадаа сэтгэл дундуур байгаа. Би сонсголгүй хүний соёлын талаар бусдад заахаар төлөвлөж байна. Коронавирусын талаарх мэдээллийг дохионы хэлээр явуулж байгаа тул энэ талаар мэдээллүүдийн хүртээмж хангалттай байгаа. Би тэр мэдээгээ гэр бүлдээ дамжуулж тэдэндээ анхаарал тавьж байгаа. Коронавирусын энэ үед

дохионы хэлээр төрийн мэдээллээс эхлээд өөр гоё мэдээллүүд авч байгаа ч коронавирусын нөхцөл байдал өнгөрөөд энэ бүхэн байхгүй болчих вий дээ гээд их санаа зовж байна. Ер нь бусад мэдээллийг ч дохиотой явуулж баймаар байна.

Сонсголгүй хүмүүсийн боловсролыг дээшлүүлэхэд зориулсан маш олон сургалт баймаар байна. Зохион байгуулагддаг ихэнх сургалтуудад сонирхоод очихоор орчуулагч байхгүй учир бид оролцож чаддаггүй. Сонсголгүй хүмүүсийг уулзуулж сэтгэл санаагаа хуваалцдаг клубтэй, тэр уулзалтад нь зочид, менторууд ирдэг ч юм уу, бид өөрсдийн гэсэн орон зайтай байхыг хүсдэг. Гадаадын их дээд сургуулиас янз бүрийн тэтгэлгүүд авахыг хүсдэг тул сонсголгүй англи хэл заадаг хүн бидэнд хэрэгтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний халамж тэтгэмж нэмэгдсэнд маш их баяртай байгаа. Үүнтэй ижил сонсголгүй хүмүүст тусгайлан зориулсан ажил хийгдээсэй гэж хүсэж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



ТҮҮХ №13

Зурагтаар хичээл үзэхээр зарим хичээлээ ойлгохгүй, тодруулж асуух боломжгүй байгаа нь надад хүндрэлтэй байна.

— 16 настай, эрэгтэй, Баянзүрх дүүрэг

Би аав ээж дүүгийн хамт ам бүл дөрвүүлээ амьдардаг. Манай ээж сонсголын бэрхшээлтэй үүнээсээ болж ажил хөдөлмөр эрхэлж чаддаггүй.

Коронавирус гарснаас хойш манай улс онц байдал зарлаж, сургуулиудын үйл ажиллагаа зогсож, хүмүүс ч гэрээсээ гарахаа больсон, хүмүүсийн сэтгэл санаа тогтворгүй, айдас түгшүүртэй болсон. Зурагтаар хичээл үзэхээр зарим хичээлээ ойлгохгүй, тодруулж асуух боломжгүй байгаа нь надад хүндрэлтэй байдаг. Мөн хичээлийн цаг дэндүү богино учраас бичиж авч амжихгүйд хүрдэг. Надад бол дэлгэцээр хичээл үзсэнээс танхимд хичээл үзэх нь илүү ойлгомжтой байсан.

Энэ нөхцөл байдлын улмаас би найз нөхөдтэйгээ уулзах минь багасч гэртээ ихэнх цагаа өнгөрөөх болсноор ганцаардаж, уйтгарлах болсон. Мөн ихэнх цагаа телевиз үзэх, интернет орчинд өнгөрөөх болсон. Цар тахлын тухай мэдээллийг телевизүүдийн мэдээнээс, мөн сошиал орчноос авч байгаа. Би хичээлээ ойлгохгүй үедээ интернетээс хичээлээ нөхөж үздэг. Энэхүү өвчин арилж, дэлхийн бүх улс орон эрүүл энх болж, өвчин дууссаны дараа хүмүүсийн сэтгэл санаа тайван бид бүхэн хэвийн амьдралдаа орно гэдэгт итгэлтэй байгаа.

Миний бодлоор бол залуусын байгууллага энэхүү нөхцөл байдалд тохируулан залуучуудад коронавирусаас хамгаалсан уриалга гаргах, хөдөлгөөнт эргүүл хийгээсэй гэж бодож байна. Засгийн Газраас ажилчдын цалин хөлсийг нэмэх шаардлагатай болов уу гэж бодож байна.

**Өвчин дэгдэхээс өмнө хэвийн байсан нөхрийн
маань ажил доголдож, үндсэндээ ажилгүй болсон.**

— 29 настай, эмэгтэй, Сонгинохайрхан дүүрэг

Би нөхөр хоёр хүүхдийн хамт дөрвүүлээ амьдардаг. Манай нөхөр хувиараа авто машин засдаг. Би гэрээрээ нэхмэлчин хийж, үйлдвэрүүдээс захиалга авч ноос, ноолууран цамц нэхэж, орос нэрийн барааны дэлгүүрт тавьж заруулдаг байсан. Хүүхдүүдийг минь харах хүнгүй байгаа болохоор би хүүхдүүдээ харангаа өрхийнхөө санхүүг бага ч болов дээшлүүлэхийн тулд интернетээс цагийн ажил олж хийдэг. Заримдаа цагийн ажлын олдоц маш бага байдаг.

Цар тахал гарснаас хойш манай гэр бүлийн хувьд гэртээ ихэнх цагаа хамт өнгөрөөх болж ЭМЯ-наас өгч байгаа зөвлөгөөг дагах шаардлагатай болсон. Цар тахал гарахаас өмнө сэтгэл санааны хувьд тайван, айх айдасгүй амьдардаг байлаа. Цэцэрлэг, сургууль ажиллаж байх үед том хүүхдээ цэцэрлэгт явуулж, бага хүүхдээ харангаа гэрээсээ ажил хийж мөнгө олдог байсан. Цар тахал гарснаас хойш манай гэр бүлийн өрхийн санхүү уналтанд орж, фэйсбүүк болон телевизээр уг өвчний тухай мэдээллийг харах болгонд сэтгэл санааны хувьд түгшүүртэй, тогтворгүй болж эхэлсэн.

Өвчин дэгдэхээс өмнө хэвийн байсан нөхрийн маань ажил доголдож, үндсэндээ ажилгүй болсон. Мөн надад захиалга өгч цамц нэхүүлдэг байсан үйлдвэрийн үйл ажиллагаа зогсож, цамцыг зарж өгдөг байсан дэлгүүр миний нэхсэн цамцыг авахаа больсон. Энэ цаг үед өмнөхөөсөө илүү их хичээх сорилттой тулгарч байна. Мөн хүүхдүүд маань байнгын гэртээ байгаа болохоор нийгмээс тусгаарлагдаж сурч хөгжих нь хязгаарлагдмал болж байна.

Энэ хүнд хэцүү нөхцөл байдалд тохируулан засгийн газар болоод залуучуудын байгууллага надаас илүү хүнд хэцүү нөхцөлд байгаа гэр бүлүүдэд туслаасай, тэднийг дэмжээсэй гэж хүсэж байна. Тэднийг дэмжихдээ мөнгө төгрөг, эд материалын тусламж үзүүлэлгүйгээр тэднийг өөрийнх нь хүчээр мөнгө олж, орлоготой болоход нь тусалж дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх шаардлагатай болов уу.

Бидний хоолны мөнгөнөөс илүүчлэн ариутгалын бодис, маск зэргийг авдаг болсноор хоолны орц багассан.

— *16 настай, эмэгтэй, Баянзүрх дүүргийн асрамжийн төв*

Хөл хорио тогтоосноос өдий хүртэлх хугацаанд тоотой хэдхэн удаа л гэрээсээ гарсан. Хөдөлгөөн хомс учраас жингээ үзэх болгонд л нэмэгдсэн байдаг. Гэхдээ биеийн жин нэмэгдэж байгаа ч хоолноосоо хангалттай хэмжээгээр шим тэжээл авч чадахгүй байгаа. Би асрамжийн газар амьдардаг бөгөөд бидний хоолны мөнгөөс илүүчлэн ариутгалын бодис, маск зэргийг авдаг болсноор хоолны орц багассан.

Цар тахлын тухай мэдээллийг телевизийн мэдээнээс өөр авах эх сурвалж байхгүй учир өдөр бүр үздэг болсон. Өдөртөө хичээл хийхээс өөр онцын ажил байхгүй ч миний сурлагын байдал базаахгүй л санагдаад байна. Асрамжийн төвд маань ганцхан телевиз байдаг. Гэтэл бид гучин хэдүүлээ амьдардаг. Мэдээж нас насны хүүхдүүдтэй учир хичээлийн цагууд ихэвчлэн давхцаж таардаг. Би хамгийн том нь болохоор дүү нарынхаа хичээлийг түрүүлж хийлгэчихээд дараа нь өөрийнхийгөө хийдэг. Гараад дууссан бол нөхөж үзэх боломжгүй. Үзэх боломжтой хичээлүүд нь хагас дутуу, ойлгоход ч бэрх тул хийсэн болоод л орхидог. Үзэх ёстой хичээлийг тухай бүрт нь тогтмол үзээгүйгээс болоод чанаргүй боловсрол эзэмших нөхцөл байдал бүрдэж байгаа.

Бид олуулаа болохоор нэг их уйдаахгүй, хоорондоо тоглож, дүү нартаа хичээл хийхэд нь тусалж өдрийг өнгөрөөж байна. Телевизийн хичээлээ бүрэн ойлгохгүй байгаагаас хамаарч бидэнд хоцрогдол үүсч, эргэлзээ төрүүлсэн зүйлээ багшаасаа тодруулж асуух ямар ч харилцаа байхгүй учир сургуульдаа л хурдан буцаж явмаар байна. Эсвэл Засгийн Газрын зүгээс теле хичээлийн чанарыг сайжруулаад, илүү хүртээмжтэй ойлгомжтой болгоод өгвөл сайхан даа. Тэгэхгүй бол би ахлах ангийн сурагч учир бусад ангийхнаасаа их хоцрогдож, нөхөж авах хэцүү болох байх.



ТҮҮХ №16

Амны хаалт зүүж эхэлснээс хойш тэрэг түрж хол зам туулдаг надад ажиллахад маш хүндрэлтэй болсон.

— 17 настай, эрэгтэй, Баянзүрх дүүрэг

Цар тахлаас өмнө би өглөө хичээлдээ явж, өдөр нь найзуудтайгаа тоглодог байсан бол одоо Нарантуул зах дээр тэрэгчин хийж амьжиргаагаа залгуулж байна. Цар тахлын хөл хорио эхэлж амны хаалт зүүж эхэлснээс хойш тэрэг түрж хол зам туулдаг надад ажиллахад маш хүндрэлтэй болсон. Олон хүн холхидог газар ажилладаг тул амны хаалтаа зүүхгүй бол өвчин авах эрсдэл ихтэй. Амны хаалттай ажиллахаар үнэхээр хэцүү, ялангуяа халуун нартай өдөр бүтэх гэж байгаа юм шиг л санагддаг. Миний ажил өглөө 7 цагаас оройн 21 цаг хүртэл үргэлжилдэг. Хэр хол явахаасаа шалтгаалан дунджаар өдөрт дөчин мянган төгрөгний цалин авдаг. Хааяа орлогогүй харих үе ч бий. Ажлаасаа ядарчихсан ирдэг болохоор аль болох хурдан амрахаа л боддог. Өглөөнөөс орой болтол ажилладаг учраас хичээлээ хийх цаг гардаггүй. Тиймээс ч хичээлээсээ хоцрогдож, сурлага маань муудаж байгаа. Гэхдээ би теле хичээлийг чанартай сайн, хүртээмжтэй байгаа гэж бодохгүй байна.

Цар тахлын тухай мэдээллийг ЭМЯ-аас болон бусад хүмүүсээс сонсдог. Хөл ихтэй газар мэдээллээс харин ч нэг хоцрохгүй шүү. Сэтгэл санааны хувьд сүртэй өөрчлөлт гараагүй. Төрөөс хүсэх зүйл гэвэл цар тахлын үе дуусахаар боловсрол руу чиглэсэн үйл ажиллагаа их явуулж өгөөсэй гэж хүсч байна.

Сурах нөхцөлийн хувьд танхимаар хичээл орох болон онлайнаар орох хоёр шал өөр.

— 19 настай, эмэгтэй, Сүхбаатар дүүрэг

Би сэтгүүлч мэргэжлээр суралцдаг оюутан учир одоо хэвлэл мэдээллийн байгууллагад дадлага хийж байгаа. Ковид-19 цар тахлын талаарх мэдээллийг өглөө болгон 11 цагт ЭМЯ дээр очиж мэдээ бэлтгэж ажилладаг болохоор тэндээс мэдээллээ авдаг.

Ковидын хөл хорио миний хувьд эерэг нөлөөтэй байгаа. Би сүүлийн 2 жилийн турш өдөрт 4 цаг унтаж, өөрийгөө дайчилж суралцаж байсан. Харин одоо ийм байхаа больж, хүссэн үедээ унтаж, хичээлээ хийх үедээ хийж байгаа учир өөртөө цаг зав хангалттай гаргаж, эрүүл мэнддээ ч гэсэн анхаардаг болсон. Ахуйн ажил бол нэмэгдсэн зүйл байхгүй, угаасаа казак хүмүүс охидуудаа гэрийн ажилд их сайн сургадаг.

Сурах нөхцөлийн хувьд танхимаар хичээл орох болон онлайнаар орох хоёр шал өөр байгаа. Хичээл хааснаас хойш эхний саруудад гэрээсээ гарахгүй, хүссэн үедээ унтаад, идээд цаг алдаж байсан бол одоо хичээлээ хичээж суралцаж байна. Цахимаар хичээлээ орох болоход манай сургуулийн багш нар ямар ч туршлагагүй, эхэн үедээ хүндрэлтэй байсан. Одоо бол багш нар хүүхэд бүрт маш сайн тусалж байгаа. Номын сан ажиллахгүй байгаа ч интернетээс бүхий л хэрэгтэй мэдээлэл, номоо олж авч чадаж байгаа. Ихэнх мэдээллээ англи хэлээр авч хэрэглэдэг. Би харьцангуй боломжтой буюу дата хүртээмжийн хувьд 5G-д холбогдсон, хотын төвд амьдарч хичээлээ хийж, нийгмийн амьдралд оролцож байна.

Манай гэр бүлийн орлого олдог хүмүүс нь гадаадад цагаачлан ажиллаж байгаа тул эдийн засгийн хувьд хомсдолд ороогүй. Харамсалтай нь над шиг юмнуудаа бэлдүүлээд жаргалтай байгаа залуу хүн цөөхөн. Боломжгүй айлын хүүхдүүдэд коронавирусын нөхцөл байдал яаж нөлөөлж байгааг төсөөлж байна. Хөдөө мал дээр хүний мал маллаж мөнгө олдог залуус зөндөө байгаа. Ажил хийж өөрсдийгөө болгодог байсан хүүхдүүд энэ үеэр ажилгүй болж байна.



ТҮҮХ №18

Зогсоогоод эсвэл ухрааж үзэж чадахгүй учир бичиж авч ч амждаггүй.

— 15 настай, эрэгтэй, Баянзүрх дүүргийн асрамжийн төв

Манай төвийн зурагт байнга л асаалттай байж байдаг. Өглөө нь бүгдээрээ сууж байгаад мэдээгээр цонхны цаана юу болж байгааг үздэг. Хөл хорионы үед төвөөс гарч чадахгүй тул ганц байгаа зурагтаараа л мэдээлэл олж авна.

Энэ үед хамгийн хэцүү байгаа нь теле хичээл л байна. Хичээл маш хурдан гараад дуусдаг. Шинэ хичээлийг тэгж хурдан заагаад өнгөрөхөөр бид яаж ойлгох билээ дээ. Хичээлийн цагууд ихэвчлэн давхацдаг. Зогсоогоод эсвэл ухрааж үзэж чадахгүй учир бичиж авч ч чаддаггүй. Бас хагас жил л үзсэн англи хэлний хичээлийг дан англиар заахаар би юу ч ойлгодоггүй. Ойлгоогүй хичээлүүдээ эгч нараараа заалгадаг. Заримдаа тэгээд ч ойлгохгүй чигээрээ үлдэнэ. Утас, компьютер байхгүй болохоор номоо үзэж чаддаггүй. Номууд маань бүгд цахим хэлбэрт шилжчихсэн гээд сурах бичиггүй байгаа. Ядаж л 2 телевизортой болоод интернет ашиглах нөхцөл бүрдүүлээд өгвөл энэ хөл хорионы үеэр хичээлээ ойлгоод байж болохоор л байна. Гэхдээ бид хүрэлцэхгүй, хангалтгүй гэж орхилгүйгээр аль болох хичээлээ тасралтгүй үзэж, ойлгохыг хичээж байгаа.

Өмнө нь би дууны дугуйлан, сургуулийнхаа клубуудэд хамрагдаж гоё зүйлс сурдаг байсан. Харин одоо цар тахлаас болоод хүссэн үедээ гарч болохгүй, сургуульдаа ч явахгүй байгаа болохоор хурдхан шиг л хуучин хэвэндээ орж, олон юм хийж сурахыг хүсэж байна.

Амьдрахын тулд бид олдсон бүх л ажлыг хийж байна.

— 26 настай, эмэгтэй, Чингэлтэй дүүрэг

Би нөхөр, хүүхдийн хамт гэр хороололд амьдардаг. Миний хувьд цэцэрлэгийн багшаар ажиллаж байгаад хөл хорио тогтоосны улмаас гэртээ байх болсон. Ковид 19-ийн үед эерэг болон сөрөг өөрчлөлтүүд аль аль нь л гарсан. Эерэг гэвэл хүүхэдтэйгээ өнгөрүүлэх цаг нэмэгдсэн. Харин сөрөг өөрчлөлт нь эдийн засгийн хүнд байдалд орсон. Нөхөр маань ажлын цомхотголд ороод одоо ажилгүй байгаа. Өнгөрсөн хэдэн сарын турш төрөөс цалингийн доод хэмжээний цалин авч байсан. Хувийн цэцэрлэгт ажилладаг учир энэ сард цалин өгөх эсэх нь тодорхойгүй байгаа. Амьдрахын тулд бид олдсон бүх л ажлыг хийж байна. Хажуугаар нь хүүхдээ харна. Төрөөс бидний төлөө юм хийж байна л гэнэ. Гэтэл тэр шийдвэрүүд нь бидэн дээр бууж ирдэггүй. Жишээ нь: Махны үнийг буулгасан л гэсэн. Бодит байдал дээрээ үхрийн махны үнэ л гэхэд хорин мянган төгрөг хүрчихсэн. Бид нар юугаараа яаж амьдрах юм бэ? Ер нь л дагаж мөрдвөл зохих журмуудыг нь хүн бүрт сайн хэвшүүлж өгөөд хөл хориогоо цуцалчихвал зүгээр санагдаж байгаа. Тэгэхгүй бол манай гэр бүл шиг сарын тогтмол орлогогүй болсон маш олон айлуудын хүүхдүүд хангалттай тэжээллэг хоол хүнс идэж чадахгүйн улмаас өвчин тусах эрсдэл нэмэгдэнэ. Зөвхөн өрхийн санхүүгийн асуудлаас болж маш олон асуудлууд гарч байгаа, тэр бүхнийг чадах чинээгээрээ зохицуулж байгаа ч энэ нөхцөл байдал удаан үргэлжилвэл улам л дордох байх гэж санаа зовж байна.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН





ТҮҮХ 20

Хоцорсон хичээлээ нөхөж чадахгүй болохоор сургуулиасаа гарахад хүрсэн.

— 19 настай, эрэгтэй, Чингэлтэй дүүрэг

Ковидын өмнө энд тэнд цагийн ажил хийж өөрийгөө болгодог байсан. Сарын орлого маань 400.000 төгрөг байсан. Харин одоо ажилгүй болж, ажлын олдоц бараг байхгүй болж байна. Энэ үед гэртээ ус авах, мод түлээ бэлдэх гэх мэт гэрийн ажил хийхээс өөр онц хийх зүйлгүй байна. Мөн ариутгал цэвэрлэгээг бол байнга хийж байгаа. Цар тахлын тухай мэдээг телевиз, фэйсбүүкээс авч, мөн хүмүүсийн амнаас зарим мэдээллийг хааяа сонсдог л юм.

Оюутан хүний хувьд цахим хичээлийн зохион байгуулалт муу санагдаж байгаа. Даалгавар өгнө, тэгээд буцаагаад явуулна. Өөр зааж байгаа юм байхгүй болохоор хичээлээсээ их хоцорсон. Хоцорсон хичээлээ нөхөж чадахгүй болохоор сургуулиасаа гарахад хүрч, өөр сургууль руу орохоор шийдсэн. Ингэхээс өөр аргагүйд хүрсэн. Цахим хичээлийг хүн бүрт хүртээжтэй байхаар төлөвлөөгүйгээс болоод над шиг байнга хийх бололцоогүй олон оюутан сургуулиа солих, сургуулиас гарах зэрэг асуудлууд зөндөө л гарч байгаа байх. Үүнийгээ дагаад зардал ч нэмэгдэж хүндэрч байна.

Яг энэ үед Засгийн Газраас цахим хичээлийн хүртээмжийг судалж, хичээлээ хийж чадахгүй байгаа залуус руу хандсан ажил хийгээсэй гэж хүсэж байна.

ТҮҮХ 21

Банкны зээлээ төлөхийн тулд машинаа зарсан.

—31 настай, эмэгтэй, Сүхбаатар дүүрэг

Нөхөр маань барилгын ажил хийдэг байсан ч корона гараад санхүүжилт байхгүй гээд компаниуд нь цалингаа өгөхөө больсон. Мөн хөдөө замын ажилд явдаг байсан ч зам хаагдаад явахаа больсон. Одоогоор манай гэр бүлийн хувьд санхүүгийн эх үүсвэр алга байна.

Бага хүүхэд маань 2 настай, цусны өвчтэй. Сардаа 1 сая төгрөгийн тариа хийлгэх ёстой байдгаас группын хөнгөлөлт гэж 500.000 төгрөг авч түүгээрээ тариа хийлгэдэг. Хүүхдийн эмчилгээний мөнгө гэж банкнаас зээл авсан бөгөөд тахал дэгдэхийн өмнө төлөөд болоод л байдаг байсан. Гэтэл одоо зөвхөн халамжийн мөнгө, хорооноос өгсөн хүнсний картаараа авдаг багахан хүнсээр амь зууж байгаа. Мөн утаснуудаа ломбарданд тавьж, хашаагаа банкинд алдаж хадмынхаа хашаанд нүүж ирсэн. Зээлээ төлөхийн тулд машинаа зарсан.

Хүүхдүүд маань цэцэрлэгт хамрагдаж чадаагүй учир хоцрогдол ихтэй. Теле хичээлээ гэртээ хийхээр ойлгохгүй, хийлгэхэд ч хэцүү байдаг. Яг энэ үед гэртээ хүүхдүүдээ харж, ариутгал цэвэрлэгээ л хийж байна.

Коронавирусын тухай мэдээллийг зурагтын мэдээгээр авч байна даа. Энэ бүхэн намжсаны дараа бүр хэцүү байна байх. Уг нь Засгийн Газраас банкны эргэн төлөлтийг царцаана гэсэн боловч царцаагаагүйгээс банк хашааг маань хураан авч зургаан сарын хугацаа өгсөн.

Бага насны 2 хүүхэдтэй болохоор би ажил хийх боломж байхгүй. Хүүхдийн мөнгийг данснаас маань банк шууд татаад авчихдаг. Мөн хүүхэд маань нэг л цус алдвал тогтоох хэцүү байдаг учир байнга хажууд нь байх хэрэгтэй байдаг. Мөн хорооноос хүнс авдаг карттай айлд багтсан ч хорооны цэвэрлэгээ зэрэг ажилд оролцохгүй бол картны хүнснээс хасна гээд байдаг нь хэцүү.

Одоо залуусынхаа ажил эрхлэлт, хүүхдийн боловсрол руу чиглэсэн ажил хийгээсэй гэж хүсч байна. Төрийн халамж нэмэгдэх тусам барааны үнэ дагаад өсдөг болохоор хүнд юм. Би чинь залуу хүн шүү дээ. Өсөж дэвжиж, амьжиргаагаа дээшлүүлэх хүсэл их байдаг. Цэцэрлэгийн багш болохыг хүсдэг ч боломж ер гардаггүй. Бидэн шиг залуу гэр бүлүүд олон бий. Тиймээс бидний дуу хоолойг хүргэх хүн, байгууллага байдаг бол цааш дамжуулаасай гэж хүсэх байна.

Залуусын олон байгууллага байгаа ч дохионы хэлмэрч байхгүй, бидний ирээдүйд зориулсан үйл ажиллагаа алга байна.

—20 настай, эрэгтэй, Баянзүрх дүүрэг

Хичээл хаагдаж хөл хорио тогтоосноор миний сурдаг коллеж хичээллэхгүй байгаа. Бидэнд зурвасаар хичээл явуулдаг ч ерөнхийдөө амралтын шинжтэй л байна даа. Хичээлтэй холбоотой мэдээлэл болон шалгалтын материалуудыг заримдаа үзэх, ойлгох боломжгүй байгаад байна. Бичгээр хичээлийн материалууд ирдэг ч багштайгаа харилцаа байхгүй нь маш хүнд байна. Коронавирус гарч хорио тогтоож хичээл хаасан болохоор ажил хийе гэж бодоод ажил хайсан ч олдоогүй. Тиймээс дүүгээ харж, хичээлийг нь хийлгээд өөрөө интернетээс хичээлээ хуулж бичдэг л ажилтай байна. Харин мэдээлэл дохионы хэлээр явдаг болсон тул коронавирусын талаарх мэдээллийг маш сайн авдаг болсон нь давуу тал юмуу даа. Корона дуусаж хичээл танхимаар ороосой гэж хүсэж байна. Халдварт өвчнөөс биеэ хэрхэн хамгаалах талаар мэдлэгтэй болсноос өөрөөр амьдралд өөрчлөлт ороогүй.

Залуусын олон байгууллага байгаа ч дохионы хэлмэрч байхгүй, бидний ирээдүйд зориулсан үйл ажиллагаа алга. Засгийн Газраас бидний бичиг үсгийн боловсролыг сайжруулж өгөөсэй гэж хүсч байна. Бүх зүйлийг давхар дохиж тайлбарладаг байвал бид бүгдийг сурмаар байна. Дохионы хэлний өгүүлбэрийн бүтэц өөр, 35 үсгээ мэдэж байгаа ч үгийн агуулга, дүрмийг ойлгоход их хэцүү, дохиогоор ярьдаг ч цаасан дээр буулгаж чадахгүй байгаа болохоор анхнаас нь цэцэрлэгийн наснаас эхлээд, маш сайн дохионы хэлтэй багш заагаасай гэж хүсч байна. Коронавирусын талаар их мэдээлэл авсан, гэвч хоорондоо уулзаж, сургалтад хамрагдаж чадахгүй хориотой байгаа нь мэдээллээс, хөгжлөөс хоцроогоод байна. Бид маск зүүгээд нийгмийн харилцаанд орж чадахгүй байгаа.

Дүгнэлт

Судалгаанд оролцсон зарим залуус гэр бүлийнхэнтэйгээ илүү цагийн өнгөрүүлж, дүү нартайгаа илүү дотно болж байгаад баяртай байгаагаа илэрхийлсэн. Мөн гэрийн ажил болон мал төллөх, ямаа самнахад тус болох зэргээр гэрийнхэндээ тус нэмэр болсондоо сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн.

Тэд бүгд Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулдаг 11 цагийн мэдээг үзсэнээр ковид-19 -ын талаарх баттай сурвалжаас үнэн бодит мэдээлэл авдаг гэж ярьсан бөгөөд хажуугаар нь интернэтээс болон эргэн тойрны хүмүүсээс мэдээлэл авдаг хэмээн зарим нь хариулсан. Өдөр бүрийн 11 цагийн ЭМЯ-ны цаг үеийн мэдээлэл дохионы хэлээр орчуулагдан явсан нь сонсголгүй хүүхэд, залууст хүртээмжтэй байв.

Залуусын хувьд олноор цуглах, үзвэр үйлчилгээ, нийтийн хоолны үйлчилгээ гэх мэт гадагшаа гарах хөдөлгөөнийг хорьсноор хамгийн их тулгамдсан асуудал нь нийгэмшлийн буюу сэтгэл санааны хямрал, ганцаардлын асуудлууд байв. Хязгаарлагдмал орчинд гэртээ удаан хугацаагаар байж, найз нөхөд, үе тэнгийнхэнтэйгээ харилцаж чадахгүй болсноор уйтгарлаж, сэтгэл санаа нь тогтворгүй болж, ганцаардсан байна.

Мөн эмзэг бүлгийн хүмүүсийн амьдралд Ковид-19 зэрэг гэнэтийн өөрчлөлт тохиолдоход шууд ядуурал, өлсгөлөн, ажилгүйдэл зэрэг эрсдэлт нөхцөлд орсон байв. Ковидын нөхцөл байдлын судалгааны үеэр ихэнх залуус өөрсдөө болон аав, ээж нь ажилгүй болсноор өмнө иддэг байсан хоолноосоо хасах, аав ээждээ туслахын тулд ажил хийхээс өөр аргагүй нөхцөл байдалд орсноо хэлж байв. Үндэсний статистикийн хорооноос гаргасан сүүлийн судалгаагаар Монгол улсын хүн амын 28.4% ядуу, 14.9% ядуурлын ирмэг дээр амьдарч байна гэдэг тоо баримт үндэслэлтэй болох нь судалгаанаас харагдав.

Залуучуудын боловсрол, амьдралын хэв маяг, хөдөлмөр эрхлэлтэд гарсан нийтлэг өөрчлөлтүүдийг шинжилж үзвэл:

Ковидын үед Засгийн газраас авсан арга хэмжээ цаг үеэ олов: Засгийн газраас гаргаж буй шийдвэрүүд бүх хүмүүст нөлөөлөх хэдий ч нөлөөллийн цар хүрээ харилцан адилгүй байна. Жишээлбэл, хил хааснаар хил давж үйл ажиллагаа явуулдаг байсан хувь хүн, аж ахуйн нэгжүүдэд хүндээр нөлөөлж байхад малчин өрхөд төдийлөн мэдрэгдэлгүй өнгөрсөн байна. Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосон нь хүүхэдтэй хүмүүс, ихэвчлэн ээжүүд хүүхдээ харах шаардлагатай болсноор ажил хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдаж, өрх гэр нь эдийн засгийн хувьд хүнд байдалд орсон. Засгийн газраас авч хэрэгжүүлсэн хүүхдийн мөнгөний хэмжээг нэмэгдүүлэх, зээл төлөлтийг хойшлуулах, хоолны талон олгох, хөгжлийн бэрхшээлтэй хүний тэтгэмжийг нэмэх зэрэг арга хэмжээнүүд нь эмзэг бүлгийн залуусын амьдралд маш их дэм болж байгааг зарим залуус дурдсан.

Эдийн засгийн эмзэг байдалд оров: Залуус ихэвчлэн цагийн, түр, гэрээт зэрэг албан бус салбарт, ихэнхдээ үйлчилгээний газар хөдөлмөр эрхэлдэг байсан нь илэрсэн. Хөл хорио тогтоож, зарим үйлчилгээний газруудын үйл ажиллагааг зогсоосноор олон хүмүүс ажилгүй болж, эдийн засгийн дарамтад орсон. Энэ байдлаа даван туулахын тулд зээл авах, хэрэглээгээ танах, хоолоо багасгах зэрэг арга хэмжээг авч байна. Өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт, маскны хомсдол, ажилгүйдэл зэрэг хотод амьдардаг залуусын амьдралд нэлээдгүй бэрхшээл тулгамдсан байна. Нэгэн залуу гэр бүл цусны өвчтэй хүүхдийнхээ эмчилгээг хийлгэхийн тулд эд хөрөнгөө барьцаанд тавьж зээл авснаа төлж чадалгүй хашаагүй болсон байна.

Амьдралын хэвшил өөрчлөгдөв: Залуус хичээл, сургуульдаа явахгүй онлайнгаар хичээлээ хүссэн үедээ үзэж байгаа тул өглөө эрт босож, олон цаг автобусанд явж түгжрэхгүй цаг хэмнэж тэр цагаа өөртөө зориулж эрүүл мэнддээ илүү анхаардаг болсон, бие даан суралцах чадвартай болж байна, өвчнөөс урьдчилан сэргийлэх, өөрийн болон гэр орны ариун цэвэртээ маш их анхаардаг болсон зэрэг эерэг дадалтай болжээ. Гэтэл телевизор, компьютерийн болон утасны дэлгэц ширтэж олон цаг өнгөрөөх, интернэтэд олон цагаар байснаар өдөр, шөнийн нойр солигдох, хөдөлгөөн багасаж таргалах зэрэг сөрөг хэвшилд бас суралцжээ. Зарим нэг залуус чөлөөт цаг ихтэй болж, хоббигоороо хичээллэх цаг завтай болсондоо баяртай байв.

Сэтгэл зүйн хувьд тогтворгүй байдалд оров: Өсвөр насны хүүхдүүдэд нийгэмшлийн хэрэгцээ хамгийн чухал байдаг бөгөөд энэ үедээ найз нөхөд, үе тэнгийнхэнтэйгээ уулзаж чадахгүй байгаа нь стресс, сэтгэл гутрал цаашлаад бусадтай харилцах харилцаанд сөргөөр нөлөөлж байгаагаа хэлж байсан. Залуу гэр бүлүүд сэтгэл санааны хувьд түгшүүртэй, тогтворгүй болж, амгалан тайван байдал алдагдсан гэж ярьсан.

Залуу охид гэртээ ихэнх цагийг өнгөрөөж байгаа тул гэрийн ажил олон цагаар хийх болжээ. Ялангуяа малчин айлын охид өмнө нь дотуур байранд амьдарч хичээлээ хийдэг байсан бол, гэрээсээ хичээллэх үед дүү нарынхаа хичээлийг хийлгэх, хонь хариулах, гэр орноо цэвэрлэх гээд ачаалал нэмэгдсэн байна.

Эцэг эхчүүд хүүхдүүдийг гэрээсээ гарахгүй байхаар нийгмээс тусгаарлагдан, сурч хөгжих нь хязгаарлагдмал болж байгаад санаа зовж байгаагаа илэрхийлсэн. Өсвөр насны хүүхэд, залуус өөрсдийгөө хөгжүүлэх үйл ажиллагаа, дугуйлан, клубт хамрагдаж чадахгүй болсондоо санаа зовж байв.

Боловсролын байдал дордов: Теле хичээлийн цагууд давхцаж, телевизийн нэвтрүүлгийг зогсоох, ухраах үйлдэлгүй эсвэл нэмэлт төлбөр төлж худалдан авах шаардлагатай тул тухайн цагтаа үзэж ойлгоогүй бол тэгээд л хоцорч байв. Эмзэг бүлгийн хүүхэд залуус гар утас, компьютер байхгүй тул цахим ном, сурах бичгийг ашиглах боломжгүй байна. Теле хичээл маш богино хугацаанд заагаад өнгөрдөг тул юу ч ойлгодоггүй, бичиж тэмдэглэж амждаггүй байна. Мөн хичээл илүү богиносгосон цагаар орж байгаа тул боловсролоороо хоцрогдоод байгаа мэт сэтгэгдэл төрдөг гэж залуус ярьсан ба ойлгохгүй зүйл гарахаар багшаасаа асуух тодруулах боломжгүй, тээнэгэлзсэн байдалд орсноо ярьсан. Тухайлбал, асрамжийн газрын ахлах ангийн сурагчид хичээлээ тогтмол үзээгүйгээс болоод ойлгохоо больж, чанаргүй боловсрол эзэмшиж байгаадаа санаа зовж байлаа.

Тархины саажилтаасаа болоод харааны бэрхшээлтэй болсон охины хувьд танхимд хичээл үзсэнээс дэлгэцээр судлах нь илүү сонирхолтой, ойлгомжтой байсан ба хоцорсон хичээлээ ангийнхаа фейсбүүк группээс нөхөн үзэх боломжтой байснаа давуу тал гэж үзэж байлаа.

Малчин айлын хүүхэд сүлжээ байхгүй газар амьдардаг тул 7 хоногт нэг өдөр сумын төв орж бүх хичээлээ үзэж, даалгавраа хийдэг бөгөөд интернет сүлжээ удаан тул олон цагаар утасны дэлгэц (компьютер байхгүй) ширтэж нүд нь өвддөг, нулимс гоождог, улайдаг болсноо хуваалцсан байна.

Цахим хичээлийн зохион байгуулалт муу байгаагаас хичээлээсээ их хоцорсон нэгэн залуу хоцорсон хичээлээ нөхөж чадахгүй болохоор сургуулиасаа гарахад

хүрсэн байна. Цахим хичээлийг хүн бүрт хүртээжтэй байхаар төлөвлөөгүйгээс болоод түүн шиг байнга хичээлээ хийх бололцоогүй олон хүүхдүүд сургуулиа солих, гарах зэрэг асуудлууд гарч байна. Үүнийгээ дагаад зардал ч нэмэгдэж өрхийн санхүү хүндрэх байх гэж тэрээр санаа бодлоо хэлэв.

Зарим залуус гэртээ хичээлээ хийх боломж муу тул номын санд 3-4 цаг сууж хичээл давтдаг байсан байна. Ингэх боломжгүй болсон тул гэртээ хичээл давтах боломж муу болж, танхимд сурдгаас үр дүн муутай сурах болсондоо сэтгэл дундуур байгаагаа нэгэн залуу хуваалцав. Сургуулийн нэгдсэн цахим платформгүй тул багш бүр өөр өөр аппликейшн хэрэглэж байгаа нь оюутнуудад хүндээр тусч байна. Багш нар цахимаар заах ур чадвар сул байгаа нь тэдний сурлагад нөлөөлж байгааг оюутнууд хэлж байв. Сургалтын төвд төлбөр төлж англи хэл судалж байсан нь мөн тасарчээ. Залуус хичээл хаасан эхний нэг хоёр сардаа бэрхшээлтэй байснаа дасч, бие даан сурах чадвар сууж эхэлснээ хуваалцав.

Ковидын халдвар болон түүнтэй холбоотой авсан арга хэмжээнүүд залуусын бүлэг бүрт өөр байдлаар нөлөөлж тусч байгаа нь ажиглагдав.

Тухайлбал, сонсголгүй залуус анх удаа үндэсний олон нийтийн телевизийн мэдээний сувгаас гадна Ковидын үеийн шуурхай цаг үеийн өдөр тутмын мэдээллийг дохионы орчуулгатай гэхдээ орчуулагчийн дохио тод томруунаар харагдах чанартай дохионы орчуулгатай мэдээг цаг алдалгүй бусад хүмүүстэй адил хүлээн авч байсан. Гэвч гадуур явахдаа маск зүүх шаардлагатай болсноор сонсголын бэрхшээлтэй залуус хоорондоо харилцах боломжгүй болгож байв.

Асрамжийн газар амьдардаг 30 хүүхдийн дунд 1 телевиз байдаг тул теле хичээлийг бүрэн дүүрэн үзэж чадахгүй, ихэнхдээ ахлах ангийн ах эгч нар нь бага дунд ангийн дүү нартаа хичээлээ үзэх боломж олгож хичээлийг нь хийлгэдэг тухайгаа хуваалцсан нь харамсалтай.

ЛГБТ залуус гэр бүлтэйгээ ихэнх цагийг өнгөрөөж байгаа тул өөрийн коммюнититэй цахим орчинд харилцаж байгаагаа гэр бүлийнхэндээ мэдэгдэж, өөрийгөө илчлэгдэх вий гэсэн айдастай амьдарч байгаагаа хуваалцсан байна.

Малчин залуус хичээлээ хийхийн тулд долоо хоногтоо нэг удаа аймгийн төв явж дата авч байгаад утсаараа интернэт орж 7 хоногийн хичээлээ нэг өдөрт багтаан хийх шаардлагатай болж байгаагаа ярьсан. Мөн тэд малаа маллах, ноолуураа зарах зэрэг өдөр тутмын амьдралдаа санаа зовнин байгаагаа хэлсэн.

5. Санал, зөвлөмж

- Залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, цагийн ажил хангалттай олдоцтой болгох
- Хөдөө орон нутгийг интернет сүлжээтэй болгож малчин залуусыг дэлхийтэй холбох
- Залуус цагийг хамтдаа, үр бүтээлтэй өнгөрүүлдэг тусгай газартай болгох
- Гэр хорооллын залуус чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлдэг газартай болгох
- Сургалтын төвүүдийг үнэгүй болгох, англи хэлнээс гадна бусад гадаад хэлийг заах
- Бэлгийн боловсролын тухай мэдлэг олгодог байх, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залууст хүртээмжтэй байдлаар олгох,
- Сурахыг хүссэн юмаа дохионы орчуулгатайгаар заадаг газартай болгох, ялангуяа англи хэлийг дохионы орчуулгатайгаар заадаг газартай болгох
- Хичээлээс бусад сургалт, уулзалт зэрэг үйл ажиллагааг онлайнгаар явуулах
- Хорионд байгаа хүүхэд залууст ганцаардлаа даван туулах, айдсаа дарах зэрэг чиглэлээр сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг болгох
- Үнэхээр боломжгүй хэсэгт эдийн засгийн тусламжийг цаг алдалгүй хүргэх
- Зайн сургалтыг сайжруулах, хүртээмжийг сайжруулах, тусгай арга хэмжээ авах
- Теле хичээлийн чанарыг сайжруулах, ойлгомжтой болгох, аль болох хурдан эргэн танхимаар хичээллэх
- Цахим хичээлийн чанар, хүртээмжид засгийн газраас цаг тухайд нь хяналт шалгалт хийх, сайжруулах
- Залуучуудыг бизнес эрхлэхэд бодитой дэмжлэг үзүүлэх

- Залууст зориулсан хөгжүүлэх үйл ажиллагааг үнэ төлбөргүй болгох, орон нутгийн засаг захиргаа хариуцан зохион байгуулах
- Их дээд сургуулийн сургалтын төлбөрийг багасгах, эмзэг бүлэгт чиглэсэн арга хэмжээнүүдийг авах
- Малчдын хүүхдийг онцгой анхаарч, зайны сургалтын хүртээмжийн асуудлыг шийдэх
- Хүүхэд, залуусын цахим аюулгүй байдалд анхаарах,
- Хичээл эргэн эхлэхэд боловсрол руу чиглэсэн үйл ажиллагаагаа их явуулах
- Цахим хичээлийн хүртээмжийг судалж, хүртээмжгүй байгаа хүүхэд залуус руу чиглэсэн бодит арга хэмжээ авах
- Ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа хүмүүст эдийн засгийн тусламж үзүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн хүүхэд залууст нийгэмтэй харьцах техник хэрэгслээр хангах, сурч боловсрох орчин бүрдүүлэх, хооронд нь уулзуулах арга хэмжээ зохион байгуулах
- Залуучуудыг дайчилсан олон ажлыг санаачилдаг байх, залуус цуглаад бусдад хөгжим заах зэргээр үйл ажиллагаа явуулах боломжийг нээх
- Залуучуудын байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулах, цахим талбарыг ашиглан мэдээлэл түгээх

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ТУНХАГ

Боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдралд, насан турш нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн түлхүүр бөгөөд иргэн бүрт чанартай боловсрол олгох нь төрийн хүлээх гол үүрэг хариуцлага гэдэгт итгэн;

Өнөөгийн тогтолцоонд боловсролыг явцуу тодорхойлдог, хүн бүрийн ялгаатай байдлыг харгалздаггүй, ялгаварлан гадуурхдаг, хангалттай санхүүжилт олгодоггүй зэргээс шалтгаалан бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад цогц хандлага дутагдаж; боловсролын тогтолцооны үр өгөөж нь хувь хүний хүсэл тэмүүлэл, нийгмийн эрэлт хэрэгцээнээс асар зөрүүтэй байсаар ирсний улмаас үнэ цэнэтэй амьдарч, амьдралын чанараа дээшлүүлэх боломж олгохгүй байгаад сэтгэл зовнин;

Энэ нь эрх мэдлийн шударга бус бүтцийг бий болгож, тэгш бус байдлыг хадгалж үлдэх арга зам болж байгааг эсэргүүцэн;

Боловсролын чанар, хүртээмж, хариуцлагатай байдлын төлөө хүчээ нэгтгэн ажиллаж, энэ үйл явцад хувь хүн, иргэний нийгмийн байгууллага, бүлгүүдийг өргөнөөр татан оролцуулж, өргөн суурьтай, зохион байгуулалттай, хүчтэй хөдөлгөөн бий болгохыг чухалчлан;

Энэ үйл явцад нийгмийн бүх бүлэг, ялангуяа эрх мэдлийн цөөнхийн оролцоог хангахыг онцлон;

Иргэд, бүлгүүдийн мэдлэг, чадварыг хөгжүүлж, тулгарсан асуудлаа гаргаж ирэх, шийдлийг шаардах, хариуцлага тооцох чадавхтай болоход нь дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн;

Боловсролын тогтолцоог хүний мэдэх, бүтээх, хүний ёсоор хамтран амьдарч, нэр төртэйгээр оршиход суралцахуйц, хувь хүний потенциал, чадвар, чадавхыг нээж, эерэг зан үйл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, хүмүүнлэг, ардчилсан, хүн бүрийн эрхийг хангасан, тэгш хүртээмжтэй болгон өөрчлөхийг эрхэмлэн;

Хүүхэд, эцэг эх, багш, орон нутгийн бүлгүүд болон үндэсний, хэлний, соёлын, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, орлого багатай иргэд зэрэг дуу хоолойгоо хүргэж, шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа бүлгүүдийг эрх мэдэлжүүлэх зорилгоор боловсролын тогтолцоо, бодлогод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бүрдүүлэх, нөлөөлөх ур чадвараа дээшлүүлэх шаардлагыг ухамсарлан;

Хүний эрх, жендэрийн тэгш эрх, үл ялгаварлан гадуурхах, хүчирхийллээс ангид, хүлээцтэй байх, нээлттэй, ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлан;

Монгол улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийг хянах, хариуцлага шаардах, бодлогод нөлөөлөх үндэсний кампанит ажил зохион байгуулах зорилгоор эвсэн нэгдсэнээ тунхаглаж байна.

2010 оны 9 сарын 3

Тэмдэглэл

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УИ
СУДАЛ

